

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХУУЛЬТАЙ ХОЛБООТОЙГООР БУСАД УЛС ОРНУУДЫН
НИЙТЛЭГ ЧИГ ХАНДЛАГА, САЙН ТУРШЛАГЫН ТАЛААР ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Багийн ахлагч:

Т.Мөнх-Эрдэнэ /Шүүгч, судлаач, LL.M-University of Vienna/

Багийн гишүүд:

Ц.Одонжав /Хуульчдын холбооны судалгааны төвийн эрхлэгч/

Ц.Мөнх-Эрдэнэ /Судлаач, LL.M-Kookmin University/

Э.Эрхбилгүүн /Судлаач, LL.M-Nagoya University/

	Австрали Улс	Бүгд Найрамдах Солонгос Улс	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Япон Улс
1. Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.8, 12.2.10, 12.2.17, 12.2.20, 12.2.21, 12.2.23-д заасан хууль тогтоомжийн төслийг боловсруулахад бусад улс оронд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийдэг эсэх, цаашид дээрх хууль тогтоомжийн төслүүдэд зардлын тооцоо хийх шаардлагатай эсэх	Бүх хуулийн төсөлд зардлын тооцоо хийх шаардлагатай (хавсралт хэсгийг үзнэ үү).	Хуулийн төсөл нь төсөвт дарамт учруулах үр дагавартай тохиолдолд зайлшгүй 5 жилээр хийнэ.	Бүх хуулийн төсөлд зардлын тооцоо хийх шаардлагатай (хавсралт хэсгийг үзнэ үү).	Хуулийн төслийг зардлын тооцоо хийх шаардлагатай эсхүл шаардлагагүй гэж ангилдаг (хавсралт хэсгийг үзнэ үү).
2. Хууль тогтоомжийн төсөлд зардлын тооцоо хийх чиг үүрэг бүхий байгууллага, парламентын ажлын алба энэ талаар ямар оролцоотой байдаг зэрэг асуудлаар бусад орнуудын туршлага	Хууль зүйн яам, Парламентын Төсвийн Оффис, Төсвийн төлөвлөлт, судалгааны агентлагууд болон мэргэжилтнүүд хамтран хэрэгжүүлдэг.	Үндэсний Ассамблейн Төсвийн бодлогын газар (цаашид бодлогын газар) нь улсын төсвийн тооцоо, санхүү, санхүүгийн удирдлага, сангийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн төслүүдэд зардлын тооцоо хийх үүргийг гүйцэтгэдэг.	Хуулийн төслийг хариуцан боловсруулж буй Холбооны яам хариуцаж, түүнийг нь зөвшилцөх байдлаар хянах чиг үүргийг Холбооны сангийн яам гүйцэтгэхээс гадна Бүндэстагаас хуулийг батлахаас өмнө буюу хуулийн төсөл байхад нь Үндэсний хэм хэмжээний хяналтын зөвлөлөөс санал дүгнэлт өгдөг байна.	Засгийн газраас хууль санаачлах тохиолдолд хуулийн төслийг боловсруулсан яам хуулийг зардлын тооцоог гаргаж сангийн яам руу илгээдэг. Сангийн яам зардлын тооцоог дахин нягтлан үздэг. Эцэст нь Засгийн газрын хурлаар авч хэлэлцдэг.

--	--	--	--	--

3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 9, 10 дугаар зүйлд заасан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ажиллах орчин нөхцөл, эрх, үүрэг хариуцлагын талаарх бусад орнуудын туршлагын талаар

Австрали Улс

Австралид хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гол үүрэг нь хуулийн төслийг боловсруулах, түүнийг парламентын хэлэлцүүлэгт бэлтгэх, төслийн техникийн болон эдийн засгийн шинжилгээ хийх, олон нийтийн оролцоог хангах явдал юм. Ажлын хэсэг нь зөвхөн Засгийн газрын мэргэжилтнүүдээс биш, төрийн бус байгууллагууд, хувийн сектор, судалгааны байгууллагуудын оролцоог хангасан байдаг.

Бүгд Найрамдах Солонгос Улс

Хууль тогтоомжийн төслийг боловсруулахын тулд олон арга замыг ашиглах боломжтой.

Төслийг бие даан боловсруулж, хуулийн төсөл боловсруулах системийг ашиглах

Үндэсний Ассамблейд хуулийн төсөл боловсруулахад зориулсан дотоод систем буюу “хуулийн төсөл боловсруулах систем” байдаг бөгөөд төсөлд шаардлагатай мэдээллүүдийг оруулснаар хуулийн төслийг хурдан бөгөөд хялбархан бүрдүүлэх боломжтой. Энгийн өөрчлөлт бүхий төсөл боловсруулахад энэ системийг ашиглахад тохиромжтой байдаг.

Үндэсний Ассамблейн хууль тогтоомжийн албаны тусламж авах

Үндэсний Ассамблейд гишүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий хуулийн алба байдаг бөгөөд засаг захиргаа, батлан хамгаалах, эдийн засаг, соёл гэх мэт янз бүрийн чиглэлд мэргэшсэн хууль тогтоогчид хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг хариуцдаг. Хуулийн төслийн үндсэн санааг хэлбэржүүлэхээр хууль тогтоогчдод хандах боломжтой боловч, ажлын ачаалал ихэссэнээс болж хугацаа их шаардагддаг. Мөн хуулийн төсөлтэй холбоотой эцсийн шийдэлд хүрэхэд бэрхшээлтэй байж болно.

Гадны мэргэжилтэн эсвэл иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах

Тодорхой асуудлын мэргэжлийн мэдлэг шаардлагатай тохиолдолд гадны мэргэжилтэн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, төслийг боловсруулах нь үр дүнтэй байдаг. Энэ хамтын ажиллагаа нь хууль тогтоомжийг зөвхөн өргөн барихаас гадна хэлэлцүүлгийн шатанд олон нийтийн дэмжлэг авахад ч тустай. Гэхдээ заримдаа үзэл бодлын зөрүүг зохицуулахад хүндрэл үүсдэг.

Ийнхүү боловсруулсан хууль тогтоомжийн төслийг 10-аас доошгүй гишүүний гарын үсэгтэйгээр өргөн барьдаг. Тодорхой асуудалд олон нийтийн анхаарлыг татах шаардлагатай үед бүр илүү олон гишүүний дэмжлэг авахын тулд намын албан ёсны байр суурийг тусгах зорилгоор хуулийн төслийг өргөн барих явдал ч байдаг. Хуулийн төсөл өргөн баригдсаны дараа тухайн Байнгын хороонд шилжин, хяналт шалгалтын хороонд хэлэлцүүлэгдэн, батлагдсаны дараа ерөнхий чуулганы үеэр эцэслэгдэн батлагддаг. Ерөнхийлөгч хуульд гарын үсэг зурсан тохиолдолд хууль хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлдэг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны засгийн газраас хуулийг төслийг боловсруулах: Тухайн хууль нь аль салбарт хамаарахаас шалтгаалж тухайн асуудлыг хариуцсан чиг үүргийн яам нь хуулийн төслийг боловсруулдаг байна. Хариуцсан холбооны яам нь хуулийн төслийг боловсруулж, холбооны бусад яамдын саналыг авна. Холбооны засгийн газар хараахан батлаагүй байгаа холбооны яамнаас боловсруулсан хуулийн төслийг "Референт төсөл" гэж нэрлэнэ. Хуулийн төслийг хууль ёсны болгоход Холбооны Хууль зүйн яамнаас гаргасан “Хууль зүйн техник”-ийн гарын авлагыг барихаас гадна Холбооны Хууль зүйн яамнаас өгсөн зөвлөмжүүдийг харгалзан үзнэ. Холбооны Хууль зүйн яам нь бусад холбооны яамнаас боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд зөвлөгөө өгч, хуулийн төслийг хууль эрх зүйн системтэй, албан ёсны үүднээс авч үздэг. Үүнээс гадна муж улсууд болон мэргэжлийн холбоод руу илгээж, санал авдаг.

Тухайн хуулийн төслийг хариуцаж буй яам /Манлайлагч яам гэж нэрлэгддэг/ нь хуулийн төслийг боловсруулахдаа өөрийн бүтцийг ашиглахаас гадна мэргэжлийн баг буюу судлаачдын багийг өргөнөөр ажиллуулдаг туршлагатай байна. Холбооны хууль зүйн яамны нийт албан хаагчдын 107 нь шүүгч, прокурор хүмүүс байдаг бөгөөд тэднийг дээд тал нь 3 жилийн хугацаанд гэрээ байгуулан яаманд зөвлөх, экспертээр ажиллуулдаг байна. Яаманд ажиллаж байх хугацаанд нь үндсэн ажлаас нь түдгэлзүүлдэг зохицуулалттай байна.

Япон Улс

Парламентаас хуулийн төслийг боловсруулах: Парламентын гишүүн хууль санаачлах тохиолдолд ямар агуулгаар хуулийн төсөл боловсруулах талаар парламентын хуулийн асуудал эрхэлсэн албанд (議員法制局) мэдэгдэнэ. Уг алба нь хуулийн төслийг боловсруулж бэлтгэдэг.

Засгийн газраас хуулийн төслийг боловсруулах: Хуулийн төслийг яам боловсруулж, бусад яам болон агентлагаас санал авч болно. Түүнийг нь засгийн газрын хуулийн асуудал эрхэлсэн алба руу илгээдэг. Уг алба нь хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэх, шүүхийн жишиг, хуулийн тайлбар, хууль зүйн техникийн хувьд алдаагүй эсэх, хуулийн үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх талаар урьдчилсан хяналт тавьдаг.

Түүнчлэн Хууль зүйн яамны дэргэд хуулийг хэлэлцэх зөвлөл (法制審議会) байдаг бөгөөд иргэдийн амьдралд шууд нөлөө үзүүлэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах тохиолдолд тус зөвлөл ажлын хэсгийг байгуулж, шаардлагатай судалгаануудыг хийдэг. Зөвлөл нь 20 гишүүнтэй, 2 жилийн хугацаатай томилогддог бөгөөд гишүүд дахин томилогдож болдог. Зөвлөлийн бүрэлдэхүүнд их сургуулийн профессор, өмгөөлөгч, шүүгч, прокурор нар багтдаг. Ажлын хэсгийг ямар бүрэлдэхүүнтэй байгуулах эсэхийг зөвлөлийн гишүүд шийддэг. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн гишүүн бус экспертүүдийг ажлын хэсэгт оруулдаг.

4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Дөрөвдүгээр бүлгийн зохицуулалтын талаар бусад улс орны туршлагын талаар

Австрали Улс

Хуулийн төслийг дараах байдлаар боловсруулдаг.

- Бодлого, санаачилга:
- Хуулийн төслийг боловсруулах
- Нээлттэй хэлэлцүүлэг ба санал авах
- Төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах
- Парламентад өргөн барих
- Парламентын хэлэлцүүлэг
- Сүүлийн хэлэлцүүлэг болон баталгаа

Бодлого, санаачилга

- **Хууль санаачлагчийн үүрэг:** Хууль санаачлагч буюу Засгийн газар эсвэл парламентын гишүүн нь **бодлогын асуудал болон нийгмийн хэрэгцээг** харгалзан хууль санаачилдаг. Энэ үе шатанд ямар асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг тодорхойлж, тэр асуудлыг шийдвэрлэх **хуулийн төслийн үндсийг тавина**.
- **Судалгаа, шинжилгээ хийх:** **Productivity Commission** болон бусад холбогдох байгууллагууд нь **эдийн засгийн, нийгмийн, болон хууль зүйн шинжилгээ хийж, төсөл хэрэгжүүлэхэд гарах зардал-ашгийн тооцооллыг** хийдэг.

Нээлттэй хэлэлцүүлэг ба санал авах

- Төрийн байгууллагууд болон **салбарын мэргэжилтнүүд** олон нийтийн байр суурийг авч, төсөлд оруулсан саналуудын үр дүнд **шинэчлэлтүүд хийх** боломжтой.
- Олон нийтийн санал асуулга

- Салбарын байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны санал

Бүгд Найрамдах Солонгос Улс

1. Анхдагч хуулийн төсөл

Шинэ хууль санаачлан батлуулахаар боловсруулдаг төсөл юм.

2. Хуулийн зарим хэсгийг шинэчлэх тухай хуулийн төсөл

Хуулийн зарим заалт, хэсгийг шинэчлэхдээ хуучин зохицуулалтыг аль болох ашиглахыг эрхэмлэнэ. Хуулийн нэрийг өөрчлөхгүй байх нь ерөнхий чиглэл боловч шаардлагатай бол өөрчилж болно.

3. Хуулийг бүхэлд нь шинэчлэх тухай хуулийн төсөл

Хуулийн зохицуулалтын 2/3-аас дээш хэсгийг шинэчлэх шаардлагатай бол бүхэлд нь шинэчлэн найруулж болно. Хууль тогтоомжийн зорилго, бүтэц өөрчлөгдөх тохиолдолд бүхэлд нь шинэчлэн батална.

4. Хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Шинэ хуулийг батлахдаа хуучин хуулийг хүчингүйд тооцох заалтыг тусгаж эсвэл тусдаа хууль гаргаж болно.

Төслийн хэл найруулга, товчлол

Товчлол нь хуульд байнга ашиглагдах нэр томъёог товчилж илэрхийлдэг. Товчлолыг зөвхөн шаардлагатай үед нь хэтрүүлэлгүй ашиглах шаардлагатай. Төслийн хэл найруулга, товчлолтой холбоотой хэд хэдэн чухал зарчим байдаг.

- Нэгдмэл байдал: Хуулийн төсөлд хэрэглэж буй нэр томъёо, хэллэгүүдийг нэгдсэн байдлаар хэрэглэх шаардлагатай. Нэг хууль дотор болон холбоотой хууль тогтоомжийн хооронд ижил нэр томъёог ижил утгатайгаар ашиглахыг эрмэлзэнэ.
- Товчлол: Хуульд удаа дараа давтагдаж буй нэр томъёог товчлон хэрэглэж болно. Гэхдээ товчлолыг хэтрүүлэн хэрэглэхээс зайлсхийж, зөвхөн шаардлагатай үед нь ашиглах ёстой. Энэ нь хуульд товч нэр томъёо ашиглах, хэтэрхий урт нэрийг удаа дараа давтахгүйгээр илэрхийлэхэд тусалдаг. Товчлон хэрэглэж буй нэр томъёо нь хууль тогтоомжийн бүтэц, агуулгад тодорхой байхын тулд эхний удаа бүтнээр нь заавал тодорхойлно.

- Зохицуулалтын тодорхой байдал: Хуулийн төсөлд үүрэг, хариуцлагыг тодорхойлохдоо илэрхий байдлаар "х ёстой" гэх мэт үг хэллэг ашиглах нь тодорхой байдлыг хангана. Энэ нь уншигчид тухайн заалтаар тогтоосон үүргийг ойлгоход хялбар болгож өгдөг.
- Хэл найруулгын зөв байдал: Тухайн хуульд ашиглагдсан үг хэллэг нь цэгцтэй, ойлгомжтой, тодорхой байх шаардлагатай. Тодорхойгүй эсвэл олон утгатай үгсээс аль болох зайлсхийх нь чухал. Хууль тогтоомжийн зорилго, утга, агуулга уншигчдад энгийн ойлгомжтой байх нь түүнийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д ихэнхдээ Холбооны засгийн газраас хуулийн төслийг санаачлан оруулдаг тул хуулийн төслийн үзэл баримтлал, хэрэгцээ шаардлагын танилцуулгыг Холбооны засгийн газрын нэрээр Бүндэстагт оруулна.

Танилцуулгыг бэлтгэхдээ дараах мэдээллийг заавал багтаадаг байна. Үүнд:

1. Тухайн хуулийн төслийн танилцуулга хэсэг
2. Холбооны Канцлераас Бүндэстагийн Ерөнхийлөгчид хандсан захидал
3. Хуулийн төслийн текст
4. Хуулийн төслийн үндэслэл /ерөнхий хэсэг/
5. Хуулийн төслийн үндэслэл /тусгай хэсэг/
6. Үндэсний хэм хэмжээний хяналтын зөвлөлөөс өгсөн санал дүгнэлт
7. Бүндэсратаас өгсөн санал зэргийг хавсаргадаг байна.

Хуулийн төслийн үйл явц болон батлагдсан хуулийн төслийг дараах платформуудаас үзэх боломжтой байна. Үүнд:

1. Холбооны хууль тогтоомжийн сан /2023 оноос хойшхи хууль тогтоомж/ https://www.recht.bund.de/de/home/home_node.html
2. Холбооны хууль тогтоомжийн сан /2022 оныг дуустал хууль тогтоомж/ https://www.bgbl.de/xaver/bgbl/start.xav#_bgbl_%2F%2F*%5B%40attr_id%3D%27willkommen%27%5D_1730075937111

Холбогдох яамдын сайт дээр мөн хууль тогтоомжийн төслийн үйл явцыг байршуулсан хэсэгтэй байдаг.

Япон Улс (хавсралт хэсгийг үзнэ үү)

Парламентаас хуулийн төслийг дараах байдлаар боловсруулна.

1. Бодит байдалд хийх судалгаа
2. Хуулийн хэрэгцээ шаардлага, агуулгыг тодорхойлох
3. Төслийг бичих

1 Бодит байдалд хийх судалгаа

Тухайн төсөлтэй холбоотойгоор социал, эдийн засаг, улс төрийн, шинжлэх ухааны хүрээнд дүн шинжилгээ хийхийн тулд мэдээлэл цуглуулна. Жишээ нь статистик мэдээлэл, холбогдох байгууллагын санал, холбогдох этгээдээс ярилцлага авах гэх мэт. Дүн шинжилгээнд үндэслэж хуулийн төслийн зураглал тодорхой болно.

2. Хуулийн хэрэгцээ шаардлага, агуулга тодорхойлох

1.1 Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

Дараах баримт бичгүүдийг бэлтгэдэг.

- Хуулийн үзэл баримтлал, нийгмийн нөхцөл байдал
- Бусад хууль тогтоомжийн нийцэл (Үндсэн хууль, эрх зүйн зарчим гэх мэт)
- Зохицуулах харилцааны хүрээ

2.2 Хуулийн агуулгыг тодорхойлох

Энэ хэсэгт хуулийн зорилго, тодорхойлолт, хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацаа зэргийг тодорхой болгодог.

3.Хуулийн төслийг бичих

Энэ хэсэгт дараах зүйлсийг анхаарч хуулийн зүйл заалтыг боловсруулах шаардлагатай.

- Тухайн зүйл заалт хэнд чиглэж, эрх зүйн ямар үр дагавар бий болгох эсэх тодорхой байх

- Зүйл заалт хоёрдмол утгагүй байх
- Энгийн хүн уншихад ойлгомжтой байх
- Хуулийн бүтэц, нэр томъёо, загвар зэргийг тогтоосон аргачлалын дагуу хийсэн байх
- Бусад хуулийн зохицол

Эцэст нь хуулийн төслийн эх хувь, агуулга зэргийг бэлэн болгоно. *Хуулийн зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах тохиолдолд хуучин зүйл заалт болон шинэчлэгдэх зүйл заалтыг харьцуулсан хүснэгт бэлдэнэ. Үүнээс гадна хэлэлцүүлгийн үеэр бусад гишүүд асуух магадлалтай асуултууд болон тэдгээрийн хариултуудыг бэлдэнэ.*

5.Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4-т заасан хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж байгаа бусад улс орнуудын туршлага

Австрали Улс

Австралид шинээр боловсруулсан хуулийн төслийг хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх үйл явц нь **хүний эрхийн нийцэл, үндсэн хуулийн шаардлагууд, олон улсын гэрээнүүдтэй нийцэх эсэх, хүний эрхийн дүгнэлт болон олон талт зөвшилцөл** дээр тулгуурласан байдаг. Энэ үнэлгээний гол зорилго нь хуулийн төсөл хүний эрхийг зөрчихгүй, ялангуяа хамгийн эмзэг бүлгүүдийг хамгаалахад чиглэгдсэн зохицуулалтыг бий болгох явдал юм.

- <https://www.humanrights.gov.au/> (Хүний эрхийн Австралийн комиссын албан ёсны сайт)
- <https://www.pmc.gov.au/> (Засгийн газрын сайд нарын албан ёсны сайт)
- Хуулийн бичиг баримт болон HRCS-ын талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй холбоотой хууль зүйн удирдамж: <https://www.aph.gov.au/> (Австралийн Парламентын албан ёсны сайт)

Бүгд Найрамдах Солонгос Улс

Засгийн Газраас хуулийн төсөл боловсруулах үе шатанд хуулийн төсөл дэх төрийн болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын тодорхой захиргааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд ард иргэдийн эрхийг хязгаарласан эсхүл үүрэг хүлээлгэсэн зохицуулалтыг “Зохицуулалт шинэтгэлийн хороо”-гоор (цаашид “хороо”) хянуулдаг байна. Ард иргэдийн эрхийг хязгаарласан, үүргийг чангатгасан зохицуулалтыг заавал Хороогоор хянуулах ба хуулийн төслийг Засгийн газрын хууль тогтоомжийн газар хянаж, Засгийн Газрын Хуралдаанд мэдүүлэх үед тус хорооны хяналтын дүгнэлтийг хавсаргах ёстой.

Энэхүү хороо нь 1998 оны 4 сард Захиргааны Журмын Ерөнхий хуулийн 23 дугаар зүйлд үндэслэн Засгийн газрын зохицуулалтын бодлогыг хэлэлцэх, өөрчлөх, зохицуулалтыг хянан боловсронгуй болгох асуудлыг цогцоор нь сайжруулах зорилгоор байгуулагдсан Ерөнхийлөгчийн дэргэдэх хороо юм. Зохицуулалтын шинэтгэлийн хороо нь 2 хорооны дарга (Ерөнхий сайд, Иргэдийн хорооны дарга), 20-25 гишүүнээс бүрдэх (ихэнх нь их дээд сургуулийн профессор, хуульч) ба одоогоор 25 гишүүнтэйгээр (иргэдээс сонгогдсон 17 гишүүн, засгийн газраас сонгогдсон 8 гишүүн) үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулалт бий болгож, чангатгахыг шаардсан хуулийн төсөл санаачилсан төрийн захиргааны төв байгууллага нь юун түрүүнд зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг хийх ба энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн зохицуулалтын зорилт, хамрах хүрээ, арга хэлбэрийг тодорхойлж, зохистой эсэхийг хянах юм.

Өөрөөр хэлбэл Захиргааны Журмын Ерөнхий хуульд өөрөө хянан шалгах тогтолцоог (7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) нэвтрүүлсэн бөгөөд ингэснээр зохицуулалтыг бий болгох, чангатгахыг хүссэн төрийн захиргааны байгууллагууд зохицуулалтын нөлөөллийн үнэлгээний үр дүнд үндэслэн холбогдох мэргэжилтнүүдээс санал авч, бие даан шалгахыг урьтал болгодог байна. Бүх төрийн захиргааны төв байгууллагууд хуулийн төсөл санаачлах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачилсан тохиолдолд зохицуулалтын асуудлаар хороо хяналт тавина. Хуулийн төсөл санаачлагч байгууллага зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг бэлтгэж тухайн байгууллагын өөрийн дотоод зохицуулалтын хяналтын хороогоор хянуулсны дараагаар тайланг хороонд хүргүүлнэ. Хороо нь төрийн захиргааны төв байгууллагуудаас ирүүлсэн тайланд үндэслэн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл зохицуулалтыг буцаан татах, сайжруулахыг зөвлөдөг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тухай тухайлсан зохицуулалт байхгүй. Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тухай тухайлсан зохицуулалт байхгүй. Жишээ болгон нэгэн хуулийн төсөлд хамаарах нийтийн сонголд зориулан Бүндэстагаас *Германы*

Музейн холбооны Ерөнхийлөгч, Д-р. Экарт Кёэнэ-д тавьсан асуултын каталоги, түүнд хариулт өгсөн байдлыг хавсралт хэсэгт орчуулан оруулав.

Япон Улс

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тухай тухайлсан зохицуулалт байхгүй. Гэхдээ парламент болон засгийн газрын дэргэдэх хуулийн асуудал эрхэлсэн алба Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар урьдчилсан хяналт хэрэгжүүлдэг. *Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш Дээд шүүхээс Үндсэн хууль зөрчсөн гэсэн нийт 12 шийдвэр гаргасан нь уг хяналт сайн хэрэгжиж байгаатай холбон тайлбарладаг.* Түүнчлэн байнгын хорооны хэлэлцүүлгийн үеэр тухайн хуулийн төслөөр ашиг сонирхол нь хөндөгдөх, тухайн асуудлаар мэргэшсэн этгээдүүдийг оролцуулж олон нийтийн сонсголыг зохион байгуулдаг. Зарим тохиолдолд байнгын хорооны гишүүд орон нутагт очиж нийтийн сонсголыг зохион байгуулдаг.

БХуулийн бүтэц, дараалал, нэр томъёоны хэсэгт дараах асуудлыг харьцуулан судлах. Үүнд: Нэр томъёоны дарааллыг хэрхэн бичиж байгаа талаар /цагаан толгойн үсгийн дараалал, зохицуулалтын дараалал г.м/, хуулийн бүтэц, дарааллыг гаргах, гарчиг оноон бүлэглэх, зүйлд хуваарилахад нийтлэг баримтлах логик уялдаа, зарчим гэх мэт;

Австрали Улс

Австралид Засгийн газрын хуулийн төсөл боловсруулах гарын авлага (**Australian Government Law Drafting Manual**) <https://www.opc.gov.au/drafting-resources/drafting-general> байдаг бөгөөд энэ нь хууль зүйн баримт бичиг боловсруулахад шаардлагатай техникийн зааварчилгаа болон бүтцийн заавар агуулсан гарын авлага юм.

Хуулийг бүтцийн хувьд ерөнхий хэсэг болон тусгай хэсэг гэж хуваадаг. Ерөнхий хэсэгт хуулийн ерөнхий зохицуулалтуудыг тодорхойлдог хэсэг бөгөөд хууль хэрэгжих нөхцөл, нэр томъёо, бүхий л хууль зүйн үндсийг тавьдаг. Тусгай хэсэгт тухайн хуульд холбоотой тодорхой асуудлууд болон журам, төрлийн хуулиудыг авч үзнэ.

Хуулийг групп болгон бүлэглэх нь үйл ажиллагааны логик, нарийвчилсан зохицуулалт хийхэд чухал үүрэгтэй. Үүний тулд гарчиг, бүлэг, зүйл, хэсэг зэргийг тодорхой хувааж, ашиглах нь хуулийн бүтэц төгс болох боломжийг бүрдүүлдэг. Хуулийн бүтцийг дараах байдлаар нарийвчлан боловсруулна.

- **Гарчиг:** Хуулийн төслийн нэрийг тодорхойлоход ашиглана.
- **Удиртгал:** Хууль тогтоомжийн зорилго, ач холбогдлыг тайлбарлана.
- **Тодорхойлолт:** Төсөлд ашиглагдах гол ойлголтуудыг тодорхойлно.
- **Гол заалтууд:** Хууль тогтоомжоор заагдсан эрх, үүрэг, дүрмүүд.
- **Хавсралт:** Төсөлтэй холбоотой нэмэлт мэдээлэл, материалыг багтаана.

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын Засгийн газрын Хууль тогтоомжийн газраас баталсан 2023 оны “Хуулийн төсөл боловсруулах болон хяналтын стандарт” нь хуулийн төсөл боловсруулахдаа баримтлах үндсэн арга, стандарт юм. Энэ стандартын дагуу хуулийн төсөл нь дараах бүтцээр зохицуулагдана:

1. Хуулийн зорилго: Хуулийн эхэнд зорилгыг тодорхойлж, хуулийг баталж буй гол утга учрыг товч тодорхойлно.
 2. Үзэл баримтлал: Хуулийн үндсэн үзэл санааг илэрхийлэх ба гол зорилготой холбоотой зарчмуудыг тусгана.
 3. Нэр томъёоны тодорхойлолт: Хуулийн онцлог нэр томъёог тодорхойлон ашиглана. Энэ нь хуулийг ойлгомжтой, маргаангүй болгох үүднээс хийгддэг. (Нэр томъёоны хэсгээр тайлбарласан зүйлүүд нь Монгол улстай харьцуулахад цөөн байдаг.)
 4. Дугаарлалт: Дугаарлалтын хувьд дан дугаарлалттай боловч нэмэлт өөрчлөлтийн хүрээнд нэмэгдсэн зохицуулалтууд давхар дугаарлалттай байдаг.
 5. Тайлбар зохицуулалт: Хуулийн агуулга, хүрээг тайлбарлаж, хэрэглэх удирдамжийг заана.
 6. Төрийн болон захиргааны байгууллагын эрх үүрэг: Хуулийн зорилго биелүүлэхэд шаардлагатай үүрэг, хариуцлагыг байгууллагуудад хуваарилах.
 7. Зохицуулалт үйлчлэх хүрээ: Хуулийн хамрах хүрээ, үйлчлэх хугацааг тодорхойлох зохицуулалт.
 8. Бусад хуультай харилцан хамаарал: Бусад хуультай уялдааг хангах, зөрчилдөхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Эдгээр зарчим нь БНСУ-ын хууль тогтоомжийн уялдаа холбоо, ойлгомжийг дээшлүүлэх зорилготой байдаг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (навсралт хэсгийг үзнэ үү)

Монгол Улсын хууль тогтоомжийн техникт шинэлэг бөгөөд сайн туршлага болохуйц асуудлуудыг энэ хэсэгт хөндлөө. Үүнд:

1. Хууль тогтоомжид гарчиг хийх техник (хуулийг хэрэглэх хэрэглэгчдэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлыг бий болгодог байна)
2. Хууль тогтоомжийн заалтыг дугаарлах техник (1990-ээд оны үед боловсруулж баталсан хуулиуд дан дугаарлалттай, 2000-2017 оны үед боловсруулж баталсан хуулиуд зүйл нь дан, хэсэг, заалт нь давхар дугаарлалттай, 2017 оноос хойш баталсан ихэнх хуулиуд зүйл нь давхар, хэсэг нь дан дугаарлалтын техниктэй байгаа нь харагддаг)
3. Дээвэр хууль буюу Тролейбус хууль /хууль зүйн техник/ хамаарна (тодорхой салбарт томоохон хуулийн шинэчлэл хийх гэж байгаа тохиолдолд тухайн салбарын эрх зүйн харилцааг хэд хэдэн хуулиар зохицуулж байвал тэдгээр хуулиудад нэг хуулиар нэгэн зэрэг нэмэлт, өөрчлөлт оруулж болдог байна)

Япон Улс (навсралт хэсгийг үзнэ үү)

Япон Улсын хувьд хуульд гарчиг хийх техникийг ашигладаг. хуулийн бүтэц нь дараах дараалалтай байдаг.

- Хэсэг
- Бүлэг
- Дэд бүлэг
- Дэд хэсэг

Тухайн хуулийн зохицуулалтын хүрээ зэргээс шалтгаалан дан болон давхар дугаарлалт ашигладаг. Хууль болгоны төгсгөлд дагалдах журмыг оруулдаг. Дагалдах журамд хууль хүчин төгөлдөр болох өдөр, онцгой тохиолдол, хуульд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд авах зарим арга хэмжээ болон цаашдаа хэрэгжүүлэх арга хэмжээг заадаг. Цаашдаа хэрэгжүүлэх арга хэмжээ гэдэг нь хууль хэрэгжиж эхэлснээс хойш тодорхой хугацаанд хуулийн хэрэгжилтийн байдал, нийгмийн нөхцөл байдлын өөрчлөлтийг харгалзан шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болгосон заалт юм.

Тухайн хуулийн онцлогоос хамааран “хариуцлага” гэсэн бүлэг байдаг. Хуулийн эхний хэсэгт нэр томъёог зааж тодорхойлох тохиолдол байдаг боловч ихэнх тохиолдолд хуулийн эхний бичигдээгүй байдаг.

	Австрали Улс	Бүгд найрамдах Солонгос Улс	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Япон Улс
7.Хуулийн төслийг өргөн мэдүүлэхэд хуулийн төслийн бүрдлийг хянах, төсөл болон бүрдэл баримт бичиг нь агуулгын хувьд чанар, бусад шаардлага хангахгүй тохиолдолд буцаах зохицуулалтын талаарх бусад улс орнуудын туршлага	<p>Дараах тохиолдолд буцаагдана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Агуулга болон чанарын алдаа 2. Үндэсний болон олон улсын хууль зүйн шаардлага хангахгүй байдал 3. Хуулийн төслийн үр дүнгийн үнэлгээ, нөлөөлөл 4. Хуулийн төслийн бүрдэл баримт бичиг дутуу 5. Хуулийн төслийн гүйцэтгэлгүй зорилго, тодорхойгүй зорилтууд 	<p>Буцаах талаар дараах шийдвэр гардаг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Татгалзах буюу батлахгүй буцаах Хуулийн төсөл дэмжигдээгүй үедээ татгалзагдана. 2. Шилжүүлэх Хуулийн төслийг дараах төрлөөр шилжүүлэн хэлэлцэх боломжтой. Хариуцсан хороонд шилжүүлэх Бусад холбогдох хороонд шилжүүлэх: . 3. Хойшлуулах буюу дахин хэлэлцүүлэх 	<p>Холбооны яамдын Үйл ажиллагааны хамтын журамд заасан хүснэгтийн 1, 2, 3, 4, 6, 8, 9-д заасан шаардлагуудыг хангаагүй буюу бүрдэл дутуу бол хуулийн төслийг буцаана. Хүснэгтийг хавсралт хэсгээс харна уу.</p>	<p>Дараах тохиолдолд буцаагдана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нэр томьёо 2. Хуулийн бүтэц, дарааллын стандарт 3. Хууль зүйн бичилт 4. Бусад хууль тогтоомжын уялдаа холбоо 5. Тухайн хууль хэнд яаж чиглэж байгаа 6. Хууль хэрэгжиж эхлэх тов бичигдсэн эсэх 6. Хуулийн хэрэгжилтийг хангах байгууллага тодорхой эсэх

	Австрали Улс	Бүгд Найрамдах Солонгос Улс	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Япон Улс
8. Хуулийн харьцуулсан судалгаанд цаг үеийн шаардлагад нийцсэн, шуурхай зохицуулалт шаардсан хуулийн төслийг хэрхэн бүрдүүлдэг талаарх туршлага	Австралид яаралтай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд зориулсан хурдан хэлэлцүүлгийн тогтолцоо байдаг. Тухайн хуулийн төслийг шаардлагатай нөхцөл болон Үндсэн хууль, эрх зүйн нийцэл талаас авч үзэн боловсруулдаг. Шуурхай хэлэлцүүлгийн талаар Парламент нь урьдчилан тохиролцсон журмаар хурдан хэлэлцэх шийдвэр гаргаж болно.	Солонгос улсад шуурхай хуулийн төслийн талаар Үндэсний Ассамблейн тухай хуулийн 85.2 (Саналыг түргэн шийдвэрлэх журам)-д зохицуулсан байдаг. Өмнөд Солонгост яаралтай горимыг Үндэсний Ассамблейн "Fast-Track" буюу түргэвчилсэн хэлэлцүүлгийн системээр зохицуулдаг. 2012 онд нэвтрүүлсэн энэ систем нь чухал хууль тогтоомжийг хурдан батлах боломжийг олгодог. Үндэсний Ассамблейн тухай хуулийн 85-2 дугаар зүйлд зааснаар уг горимыг ашиглахын тулд гишүүдийн гуравны хоёр буюу 300 гишүүний 180 нь дэмжиж санал өгөх шаардлагатай.	Холбооны Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх өгүүлбэрт "... Холбооны Засгийн газар хуулийн төслийг Бүндэсратад шилжүүлэх саналдаа онцгой тохиолдол буюу онцгой яаралтай гэж тодорхойлсон бол Бүндэсратаас Бундестагт гурван долоо хоногийн дараа ..." гэж, Холбооны яамдын Үйл ажиллагааны хамтын журмын 51 дүгээр зүйлийн 8-д "онцгой тохиолдол буюу яаралтай журмаар өргөн мэдүүлсэн эсэх (Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх хэсэг)" гэж тус тус заасны дагуу Холбооны Засгийн газраас онцгой тохиолдол буюу онцгой яаралтай гэж тодорхойлсон бол түргэвчилсэн журмаар хуулийн төслийг хэлэлцэх боломжтой байна	Парламентын тухай хуулийн 56.2-т Яаралтай тохиолдолд хууль санаачлагчийн хүсэлтээр байнгын хорооны хэлэлцүүлгийг түргэвчилж болно гэж заажээ. Гэхдээ ямар үндэслэлээр шуурхай процедур явагдах талаар хуульд заагаагүй байна. Байнгын хорооны хурлыг түргэвчлэх тухай саналыг парламентын дарга хүлээн аваад удирдлагын байнгын хороотой зөвлөлдсөний дараа парламентын хурлаар шийдвэрлэдэг.

	Австрали Улс	Бүгд найрамдах Солонгос Улс	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Япон Улс
9. Хуулиар эрх олгож буй дүрэм, журмын төслийг хуулийн төсөл өргөн мэдүүлэхдээ хамт өргөн мэдүүлдэг эсэх туршлага	Зарим тохиолдолд хамт өргөн мэдүүлдэг. Энэ нь тухайн хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнг сайжруулахад тусалдаг. Гэсэн хэдий ч, ихэнх тохиолдолд, хууль болон дүрэм, журмыг бие даан боловсруулж, батлах практик давамгайлдаг.	Тухайн хуулийн хэрэгжилтийг хангах зайлшгүй шаардлагатай дүрэм журам, журмын анхны хувилбарыг хамт оруулах боломжтой. Хуулийг баталсны дараа нарийвчилсан дүрэм, журмыг тухайн асуудлыг хариуцсан төрийн байгууллагууд боловсруулж гаргадаг.	Хуулийн төсөлтэй хамт журмыг өргөн мэдүүлэх практик үндсэндээ байхгүй.	Хуулийн төсөлтэй хамт журмыг өргөн мэдүүлэх практик үндсэндээ байхгүй.

10. Журам, хуулийн зохицуулалтын тодорхойлолт, ялгааг хуульчилсан байдал

Австрали Улс

Австрали улсад хууль тогтоох байгууллага (Парламент) нь хуулийг батлах үүрэгтэй, харин Засгийн газар, түүний агентлагууд нь энэ хуулийг хэрэгжүүлэхийн тулд журам, дүрэм боловсруулах үүрэгтэй байдаг. Австралид эрх зүйн шинэчлэл буюу журам цөөлөх/энгийн болгох (regulatory reform or regulatory simplification) процесс байдаг.

Журам цөөлөх үйл явц нь зөвхөн хуулийн болон захиргааны хүндрэлийг бууруулж, үйл ажиллагааг хөнгөвчлөхөөс гадна бизнес, иргэдийн хувьд үр ашигтай, амьдралд нийцсэн зохицуулалтуудыг бий болгох зорилготой байдаг. Австрали улсад энэ үйл явц нь **шинжилгээ, зөвшилцөл, шинэ журам танилцуулах, хяналт тавих** гэсэн хэд хэдэн алхамтай бөгөөд иргэдийн оролцоо, мэргэжилтнүүдийн зөвлөмжийг чухалчилдаг.

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар хууль тогтоох эрх мэдлийг зөвхөн Үндэсний Ассамблей эдэлнэ. Хуулийн тухай тодорхойлсон эрх зүйн баримт бичиг байхгүй ч хуулийг дараах байдлаар ойлгоно. Хууль нь Үндэсний Ассамблейгаас баталсан бичмэл хууль байх бөгөөд Үндсэн хуультай харьцуулахад хууль нь иргэний эрх, үүрэгтэй холбоотой асуудлыг илүү тодорхой зохицуулж, захиргааны үйл ажиллагааны үндэс болдог тул эрх зүйн тогтолцооны хамгийн чухал үндэс суурийг бүрдүүлдэг гэж хэлж болно.

Солонгос улсад 2024 оны 1-р сарын 18-наас эхлэн Захиргааны зохицуулалтын ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ хууль нь захиргааны журам, тэдгээрийн боловсруулалт, хэрэгжилттэй холбоотой зарим онцгой зохицуулалтыг агуулдаг. Хуулийн гол агуулга нь захиргааны журмууд нь хуульд үндэслэсэн байх, иргэдийн эрхийг хязгаарлахгүй байх, мөн төрийн байгууллагууд дүрэм, журам тогтоохдоо иргэдийн эрх, аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн байх ёстойг тодорхойлсон.


Захиргааны журам нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тодорхой нөхцөлд хүлээлгэх үүрэгтэй байдаг. Энэ хуулиар журмын нөлөөллийн шинжилгээ хийх, иргэдийн амьдралд үзүүлэх үр дагаврыг урьдчилан тооцоолохыг шаарддаг бөгөөд зөвшөөрлийн хугацааг тодорхойлж, үр дүнтэй байх хугацааг хязгаарлах боломжтой. Журмын тоог бууруулах, шаардлагагүй журмуудыг цуцлах, үр дүнгүй журмуудыг сайжруулах ажлуудыг Засгийн газар, захиргааны байгууллагууд хамтран хэрэгжүүлэхээр заасан.

Мөн хуульд нийцээгүй захиргааны журам хэрэглэхийг хориглодог бөгөөд төрийн байгууллагууд зөвхөн хуульд заасан хүрээнд журмуудыг тогтоох боломжтой. Засгийн газар эдгээр журмуудыг ил тод, шударга байдлаар шинэчилж, олон нийтэд зарлан мэдээлэх үүрэгтэй.

Нэмэлтээр дурдахад Солонос улсад одоогоор шинчлэлийн хүрээнд 11,000 орчим журам 5 жилийн хугацаанд засварлагдана хэмээн үзэж байна. Засгийн газрын яамдууд эдгээр журмыг шалгаж, хэрэггүй болсон журмуудыг цуцалж, үр дүнгүй журмуудыг сайжруулах зорилгоор ажиллах бөгөөд энэ үйл явц нь хэтрүүлэн тогтоосон журамтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд тустай болно хэмээн үзэж буй аж.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Хуулийг дотор нь формаль хууль, материаллаг хууль хэмээн ангилдаг бөгөөд формаль хууль гэдэг нь хууль тогтоох эрх бүхий байгууллагаас батлан гаргаж буй хууль, харин материаллаг хууль гэдэг нь хууль тогтоох байгууллагаас биш, харин хэн бүхэнд үйлчлэх эрх зүйн үр дагавартай эрх зүйн хэм хэмжээг тогтоох эрхийг хуулиар олж авсан захиргааны байгууллагаас гаргаж буй захиргааны хэм хэмжээний актыг хэлдэг. Дүрслэн үзүүлбэл:



Япон Улс

Япон Улсын Үндсэн хуулийн 98 дугаар зүйлд Үндсэн хууль бол улсын дээд хүчин чадалтай эрх зүйн хэм хэмжээ, түүнд нийцээгүй бусад эрх зүйн хэм хэмжээ хүчингүй байна гэж заасан.

Хуулиар зөвхөн иргэдийн эрхийг хязгаарлах, үүрэг оногдуулна гэж үздэг. Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т “Парламентын доод болон дээд танхимд хамаарах журмыг тухайн танхим батална”, тус хуулийн 73 дугаар зүйлийн 73.6-д “Үндсэн хууль болон хуулийг хэрэгжүүлэхийн тулд захиргааны хэм хэмжээний акт гаргах боловч хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хариуцлага оногдуулах тухай заах боломжгүй”, тус хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-т “ Улсын Дээд шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, өмгөөлөгч, шүүхийн дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар журам гаргана” гэж тус бүр заасан байна.

Засгийн газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуулиар зөвшөөрсөн тохиолдолд иргэдийн эрхийг хязгаарлах , үүрэг оногдуулах тухай захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхтэй гэж заажээ. Төрийн захиргааны байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлд яамны сайд хууль болон Засгийн газрын шийдвэрт заасан тохиолдолд захирамж гаргах эрхтэй гэжээ.

Дээрхээс үзэхэд хуулиар зөвхөн иргэдийн эрхийг хязгаарлах, үүрэг оногдуулах бол журмаар хүний эрхэд халдах боломжгүй байна. Түүнчлэн, захиргааны хэм хэмжээний акт нь Үндсэн хууль болон хуулийг хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эрх зүйн хэм хэмжээ бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд хариуцлага ногдуулах тухай зааж болохгүй.

Хавсралтууд

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.8, 12.2.10, 12.2.17, 12.2.20, 12.2.21, 12.2.23-д заасан хууль тогтоомжийн төслийг боловсруулахад бусад улс оронд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийдэг эсэх, цаашид дээрх хууль тогтоомжийн төслүүдэд зардлын тооцоо хийх шаардлагатай эсэх

Австрали Улс

Өртөг тооцох анализ хийх үндсэн алхмууд:

1. Өртөг, ашгийг тодорхойлох: Төсөл эсвэл бодлого хэрэгжүүлэхэд шаардагдах нийт өртөг болон үүнээс гарах үр ашгийг тооцно. Энэ нь шууд зардал, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардал, байгаль орчны нөлөө гэх мэт зүйлийг хамарна.
2. Өртөг, ашгийг мөнгөн дүнгээр үнэлэх: Төсөл эсвэл шийдвэрийн ач холбогдол, үр ашиг нь эдийн засагт хэрхэн нөлөөлж буйг мөнгөн дүнгээр тооцоолно. Зарим тохиолдолд энэ нь байгаль орчны эсвэл нийгмийн үр өгөөжийг үнэлэхэд төвөгтэй байдаг, гэхдээ үндсэн зорилго нь эдийн засгийн үр ашиг, өртгийг хамгийн сайн харьцуулах явдал юм.
3. Үр ашгийн үеийг тооцох: Төслийг хэрэгжүүлэх хугацаа болон эхний хөрөнгө оруулалт, цаашид гарах үр ашиг, зардлын хоорондох харьцааг урт хугацаанд тооцно.
4. Эрсдэлийг үнэлэх: Эрсдэл, боломжууд болон тухайн төслийн амжилт, бүтэлгүйтлийн магадлалыг харгалзан үзнэ.
5. Үр ашгийн хэмжүүрүүдийг тодорхойлох: Үр ашиг болон өртгийг тодорхойлолт болгож, "нутгийн орчинд" эсвэл "улс даяар" зэрэг нь тусгай чиглэлд чиглүүлж тооцоолно.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Хууль тогтоох үйл ажиллагааны тойм¹

Парламентаас баталсан хуулийн тоо, жилд

107

(2023)

Өмнөх парламентын баталсан хуулийн тоо /2017-2021/

537

(2021-10)

Парламент өөрөө санаачлан баталсан хуулийн тоо /2017-2021/

100

(2021-10)

Засгийн газраас санаачлан батлуулсан хуулийн тоо /2017-2021/

437

(2021-10)

Нийт баталсан хуульд Парламент өөрөө санаачлан баталсан хуулийн эзлэх хувь

19%

¹ Энэхүү тоймыг <https://data.ipu.org/parliament/DE/DE-LC01/law-making-oversight-budget/law-making-oversight-budget/> линкээр үзэж болно

(2021-10)

Хоёр танхим хуулийн төслийн талаар зөвшилцөж чадахгүй бол үр дүн

Үндсэндээ Бундестагийн баталсан хуулийн төсөлд зөвхөн Бундесрат хориг тавих эрхтэй. Энэ тохиолдолд Бундестагийн гишүүдийн олонхын саналаар Бундесратын эсэргүүцлийг хүчингүй болгож болно. Гэсэн хэдий ч зарим хуулийн төсөлд (Үндсэн хуульд дурдсан байдаг) Бундесратаас заавал зөвшөөрөл авах шаардлагатай. Хэрэв энэ зөвшөөрлийг үгүйсгэвэл хуулийн төсөл амжилтгүй болдог.

Хэм хэмжээ: Холбооны Үндсэн хууль, Зүйл 77 & 78

Хууль тогтоох ажиллагаан дахь Төрийн тэргүүний оролцоо

Парламентаас баталсан хууль тогтоомжид Төрийн тэргүүний зөвшөөрөл шаардлагатай эсэх

Тийм

Sources:

Германы хууль зүйн шинжлэх ухаанд давамгайлсан үзэл баримтлалын дагуу Холбооны Ерөнхийлөгч зөвхөн Үндсэн хуулийн заалтын дагуу хууль батлагдаагүй (хэлбэрийн хувьд Үндсэн хууль зөрчсөн) эсвэл агуулгын хувьд Үндсэн хууль зөрчсөн нь илт байгаа тохиолдолд л хуулийг төслийг зөвшөөрөхөөс татгалзаж болно.

Хэм хэмжээ: Холбооны Үндсэн хууль, Зүйл 82

Төрийн тэргүүн хууль тогтоомжийг батлахаас татгалзсан тоо, жилд

0

(2023)

Төрийн тэргүүн хууль тогтоомжийг зөвшөөрөхөөс татгалзсаны үр дагавар

Цаашаа өөр арга хэмжээ байхгүй. Хууль тогтоомж батлагдахгүй.

Парламент болон Төрийн тэргүүн санал нийлэхгүй бол эцсийн шийдвэрийг гаргах этгээд

Холбооны Ерөнхийлөгч

Япон Улс

Парламент болон Засгийн газраас санаачилсан хуулийн төсөл

Он	Засгийн газраас санаачилсан хууль			Парламентын гишүүдээс санаачилсан хууль		
	Өргөн мэдүүлсэн хууль	Батлагдсан	хувь	Өргөн мэдүүлсэн хууль	Батлагдсан	хувь
2023	72	70	97.2	95	16	16.8
2022	83	82	98.8	121	23	19.0
2021	65	63	96.9	100	23	23.0
2020	66	62	93.9	89	13	14.6
2019	72	68	94.4	96	22	22.9
2018	78	73	93.6	159	29	18.2

2017	75	71	94.7	164	12	7.3
2016	75	68	90.7	198	31	15.7
2015	75	66	88.0	72	12	16.7
2014	112	100	89.3	107	29	27.1
Нийт	773	723	93.5	1,201	210	17.5


БНСУ:

БНСУ-н хувьд хууль санаачлах, өргөн барихад Үндэсний Ассамблейн гишүүдийн оролцоо өндөр байдаг байна. Сүүлийн судалгаагаар 21 дэх удаагийн БНСУ-н Үндэсний Ассамблей (2020 оны 5-р сарын 30-аас 2024 оны 5-р сарын 29 хүртэл) нийт 24,381 хуулийн төслийг хэлэлцүүлжээ. Үүнээс ҮА гишүүд 22,567-г, хороодын дарга нар 1,078-г, харин Засгийн газар 736-г санаачилжээ. Эдгээрээс 7,495 буюу нийт төслүүдийн 30.74% нь хэлэлцэгдэж дууссан бөгөөд тэдгээрээс 350 нь татгалзагдсан, хүчингүй болсон эсвэл буцаагдсан байна. Үр дүнд нь нийт хуулийн төслийн зөвхөн 29.31% нь батлагджээ.

2024 оны 5 дугаар сарын байдлаар нийт 16,886 төсөл Үндсэн чуулганд хэлэлцэгдэхгүйгээр хүлээгдэж байгаа бөгөөд хэрэв 2024 оны 5-р сард дуусах хугацаанаас өмнө батлагдахгүй бол автоматаар хүчингүй болох юм.

21 дэх удаагийн Үндэсний Ассамблейн хуулийн төсөл хэлэлцүүлэлтийн үр дүн өмнөх парламентаас доогуур байна. Өмнө нь үр дүн багатай гэж шүүмжлэгдэж байсан 20 дахь Үндэсний Ассамблей нийт төслүүдийн 36.45%-ийг, харин 19 болон 18 дахь Үндэсний Ассамблей тус бүр 41.68% болон 44.40%-ийг баталсан байв.

Мөн хуулийн төсөл хэлэлцүүлэх дэд хороо, байнгын хороодын үйл ажиллагаа бага идэвхтэй байгаа юм. 2020 оны 5-р сараас 2023 оны 5-р сарын хоорондох гурван жилийн хугацаанд үндсэн 16 байнгын хороо сар бүр дунджаар 1.88 удаа, харин хуулийн төсөл хэлэлцэх дэд хороо сар бүр дунджаар 0.66 удаа хуралдсан байна.



18~21대 국회에서 발의된 법안 중 통과된 법안의 비율. (출처=국회 의안정보시스템 / 편집=황수오 기자)

4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Дөрөвдүгээр бүлгийн зохицуулалтын талаар бусад улс орны туршлагын талаар

Япон Улс

Хуульд өөрчлөлт оруулсан хэсэг болон хуучин хэсгийг харьцуулсан байгаа нь

〇〇新旧対照表		
新	旧	備考欄
<p>第2章 採用</p> <p>第6条（採用） 会社は、15歳以上の者で入社を希望する者の中から採用試験に合格し、所定の手続きを経た者を従業員として採用する。</p> <p>第7条（採用試験） 採用試験は、入社希望者に対して、次の書類の提出を求め、筆記試験、面接により選考を行い、従業員としての適合性を勘案して合格者を決める。 ただし、筆記試験は省略することがある。 ① 履歴書（写真貼付のもの） ② 特殊技能を有する者はその資格証明書 ③ その他会社が必要とする書類 <u>（削除）</u></p> <p>第8条（試用期間） <u>新たに従業員として採用された者は、入社の日より3ヶ月間を試用期間とする。</u></p> <p>（略）</p>	<p>第2章 採用</p> <p>第6条（採用） 会社は、入社を希望する者の中から採用試験に合格し、所定の手続きを経た者を従業員として採用する。</p> <p>第7条（採用試験） 採用試験は、入社応募者に対して、次の書類の提出を求め、筆記試験、面接により選考を行い、従業員としての適合性を勘案して合格者を決める。 ただし、筆記試験は省略することがある。 ① 履歴書（写真貼付のもの） ② 特殊技能を有する者はその資格証明書 ③ その他会社が必要とする書類 ④ 戸籍謄本</p> <p>（略）</p>	<p>（追加）</p> <p>（変更）</p> <p>（削除）</p> <p>（新設）</p> <p>（略）</p>

Мэдээллийн технологитой холбоотойгоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга

令和5年12月
法務省民事局

民事訴訟法（IT化関係）等の改正に関する法律（概要）

IT化の現状	検討の経緯	
<p>現状では、例えば、次のとおり、民事訴訟の手のIT化は、限定的</p> <p>① 訴えの提起は書面の提出による ② 口頭弁論（法廷）のウェブ参加は認められていない ③ 記録（書面）の閲覧は裁判所で行わなければならない</p>	<p>令和2年2月21日 法制審議会への諮問 令和4年2月14日 要綱決定 令和4年3月8日 法律案閣議決定 令和4年5月18日 成立（令和4年法律第48号）</p>	
<p>民事訴訟制度のIT化</p> <p>一層の迅速化及び効率化等を図り、民事裁判を国民がより利用しやすいものとする観点から、民事訴訟法を見直し、民事訴訟制度を全体的にIT化</p>		
<p>① オンライン提出等</p> <p>(1) 訴状等のオンライン提出が一律に可能 【民訴132条の10等関係】</p> <p>(2) 裁判所からの送達をオンラインによることも可能 【民訴109条-109条の4等関係】</p> <p>※ 弁護士等は、オンライン提出・受取を義務化 【民訴132条の11関係】</p>	<p>② ウェブ参加等</p> <p>(1) ウェブ参加が可能な期日（ex. 口頭弁論）の拡充・要件の緩和 【民訴87条の2等関係】</p> <p>(2) 電話（音声のみ）による参加が可能な期日の要件の緩和 【民訴170条等関係】</p>	<p>③ 記録の閲覧等</p> <p>(1) 訴訟記録を原則電子化 【民訴132条の12・132条の13、160条、252条等関係】</p> <p>(2) 当事者はインターネットで裁判所のサーバにアクセスして閲覧等が可能 【民訴91条の2関係】</p>
<p>当事者の申出による期間が法定されている審理の手の創設</p> <p>◇ 現行民訴法には、審理期間を定めた規定はなく、当事者は、審理終結等の時期の見込みが立たない。</p> <p>当事者双方の申出・同意があれば、一定の事件につき、手続開始から6月以内に審理終結、そこから1月以内に判決をする制度の創設【民訴381条の2-381条の8関係】</p>		
<p>住所、氏名等の秘匿制度の創設</p> <p>◇ 現行民訴法では、当事者の記録閲覧に制限はなく、訴状等に記載された相手方当事者の住所、氏名等の閲覧が可能</p> <p>社会生活を営むのに著しい支障を生ずるおそれがあるとき（当事者がDVや、犯罪被害者であるケース等）は、当事者の住所・氏名等を秘匿することを可能とする制度の創設【民訴133条-133条の4関係】</p>		
<p>人事訴訟・家事事件手のIT化</p> <p>◇ 人事訴訟・家事調停では、現実に出頭しない限り、離婚・離縁の和解・調停の成立や合意に相当する審判の前提となる合意は不可</p> <p>ウェブ会議を利用して、離婚・離縁の和解・調停の成立、合意に相当する審判の前提となる合意を可能とする仕組みの創設【人訴37条、家事268条関係】</p>		
<p>一部先行施行</p> <p>○ 住所、氏名等の秘匿制度 令和5年2月20日施行</p> <p>○ 電話による期日への参加の要件緩和 令和5年3月1日施行</p> <p>○ ウェブ会議による口頭弁論の期日への参加 令和6年3月1日施行 ※ 家裁の新設（人事訴訟等）の口頭弁論は、令和6年3月1日から1年6月以内</p> <p>○ ウェブ会議による離婚・離縁の和解・調停の成立等 公布後3年以内</p>		
<p>本格施行</p> <p>公布後4年以内</p> <p>※ 公布の日 令和4年5月25日</p>		

5. Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4-т заасан хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж байгаа бусад улс орнуудын туршлага

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

